



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТ

АУДИТЫН КОД: АХГ-2022/15/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261628 Цахим хаяг: narangerelba@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	12
3.5.1 Авлага	12
3.5.2 Урьдчилгаа	13
3.5.3 Бараа материал	13
3.5.4 Өр төлбөр	14
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21
5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын их хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ДАРГА Л.ДАШДЭМБЭРЭЛ
ТАНАА

2022.03.25 № 01/724
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүгнэлтийн үндэслэлд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 5,334.6 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	192,858,535,734.50	161,428,281,174.56
33	АВЛАГА	192,839,158,234.50	161,368,145,589.56
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	48,000.00	48,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	100,924,350,294.58	87,346,394,179.92
33400	Зээлийн хүүгийн авлага	79,324,249.30	207,471,324.18
33500	Бусад авлага	4,228,970,154.53	4,155,706,161.53
33510	Байгууллагаас авах авлага	3,028,100,696.00	3,019,990,797.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,200,869,458.53	1,135,715,364.53
33600	Зээлийн авлага	87,606,465,536.09	69,658,525,923.93
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	77,381,965,536.09	59,434,025,923.93
33612	Хувь хүмүүст олгосон зээл	44,151,997,345.52	42,542,236,707.36
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	33,229,968,190.57	16,891,789,216.57
33620	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	10,224,500,000.00	10,224,500,000.00
33623	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	10,224,500,000.00	10,224,500,000.00
34	УРЬДЧИЛГАА	17,355,000.00	54,653,085.00
34600	Урьдчилж гарсан зардал	17,355,000.00	54,653,085.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,022,500.00	5,482,500.00
35400	Хангамжийн материал	2,022,500.00	5,482,500.00
35440	Түлш, шатах тослох материал	730,000.00	3,330,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,292,500.00	2,152,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	192,858,535,734.50	161,428,281,174.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,514,227,724.76	30,747,873,521.61
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,531,780,745.59	19,958,678,521.00
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,612,130,252.00	0.00
41210	Төгрөг	1,612,130,252.00	0.00
41212	Хувь хүмүүст олгосон зээл	1,612,130,252.00	0.00
41300	Өглөг	675,166,961.34	23,459,521.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,443,821.00	1,027,921.00
41350	Зээлийн хүүгийн өглөг	74,184,143.34	0.00
41360	Бусад өглөг	595,538,997.00	22,431,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	199,993,384.00	19,595,600.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	395,545,613.00	2,836,000.00
41400	Урьдчилж орсон орлого	18,244,483,532.25	19,935,219,000.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	18,244,483,532.25	19,935,219,000.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,982,446,979.17	10,789,195,000.61
42200	Урт хугацаат зээл	15,982,446,979.17	10,789,195,000.61
42210	Төгрөг	15,982,446,979.17	10,789,195,000.61
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	15,982,446,979.17	10,789,195,000.61
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	156,344,308,009.74	130,680,407,652.95
51	Засгийн газрын хувь оролцоо	156,344,308,009.74	130,680,407,652.95
51200	Хуримтлагдсан үр дүн	156,344,308,009.74	130,680,407,652.95
51210	Өмнөх үеийн үр дүн	156,105,685,423.96	156,420,846,197.74
51220	Тайлант үеийн үр дүн	238,622,585.78	(25,740,438,544.79)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	192,858,535,734.50	161,428,281,174.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	59,253,758,980.74	53,766,380,637.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,804,578,930.74	53,683,033,037.62
120	Нийтлэг татварын бус орлого	38,804,578,930.74	53,683,033,037.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,804,578,930.74	53,232,040,309.89
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,265,790,465.32	41,263,591,941.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,333,665,893.70	11,615,077,030.89
1200046	Зээлийн хүүгийн орлого	205,122,571.72	353,371,337.45
120009	Бусад орлого	0.00	450,992,727.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,449,180,050.00	83,347,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	20,330,238,400.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	20,330,238,400.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,941,650.00	83,347,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	43,457,350.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	39,890,250.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,941,650.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	58,647,427,197.47	79,509,571,160.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,647,427,197.47	79,509,571,160.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	907,404,851.73	1,105,043,147.00
2104	Хангамж, бараа материалын зардал	350,914,235.00	10,000,000.00
210401	Бичиг хэрэг	19,306,650.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	15,821,160.00	0.00
210404	Ном, хэвлэл	33,713,000.00	10,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	278,310,825.00	0.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,762,600.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	144,694,921.73	345,887,665.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	140,751,421.73	300,352,092.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,943,500.00	45,535,573.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	411,795,695.00	749,155,482.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	254,343,495.00	431,307,382.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	157,452,200.00	317,848,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,740,022,345.74	78,404,528,013.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,740,022,345.74	77,993,018,079.24
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,740,022,345.74	77,993,018,079.24
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	4,097,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	4,097,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	407,412,934.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	403,972,934.73
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0.00	3,440,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	606,331,783.27	(25,743,190,523.35)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	2,751,978.56
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	2,751,978.56
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	367,709,197.49	0.00

225002	Найдваргүй авлагын алдагдал	15,197,800.00	0.00
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	352,511,397.49	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	238,622,585.78	(25,740,438,544.79)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			156,125,644,712.96	156,125,644,712.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(19,959,289.00)	(19,959,289.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			156,105,685,423.96	156,105,685,423.96
Тайлант үеийн үр дүн			238,622,585.78	238,622,585.78
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			156,344,308,009.74	156,344,308,009.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			76,538,188.00	76,538,188.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			156,420,846,197.74	156,420,846,197.74
Тайлант үеийн үр дүн			(25,740,438,544.79)	(25,740,438,544.79)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл			130,680,407,652.95	130,680,407,652.95

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	211,186,991,752.53	175,400,610,249.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	166,207,460,103.92	145,422,676,430.97
120	Нийтлэг татварын бус орлого	166,207,460,103.92	145,422,676,430.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	166,207,460,103.92	145,422,676,430.97
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,342,792,110.79	42,297,676,655.83
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,433,305,219.84	10,458,705,246.29
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	95,016,362,773.29	92,666,294,528.85
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,415,000,000.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	44,979,531,648.61	29,977,933,818.83
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	30,311,222,290.61	28,294,435,319.65
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	20,330,238,400.00	0
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	0	28,294,435,319.65
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	9,980,983,890.61	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,668,309,358.00	1,683,498,499.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,135,003,808.00	1,273,794,140.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00	39,890,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,413,248,100.00	357,814,109.18

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,057,450.00	12,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	208,962,491,752.53	175,400,610,249.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	208,962,491,752.53	175,400,610,249.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,192,427,353.73	979,303,747.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,838,000.00	-
210404	Ном, хэвлэл	22,838,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	303,074,658.73	220,624,115.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	251,444,721.73	172,938,542.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	51,629,937.00	47,685,573.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,866,514,695.00	758,679,632.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	734,061,495.00	439,381,432.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,132,453,200.00	319,298,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	206,770,064,398.80	174,421,306,502.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,881,441,608.52	87,099,685,115.88
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,881,441,608.52	87,099,685,115.88
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	100,924,350,294.58	87,318,181,386.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,332,754,199.58	85,957,565,193.57
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,591,596,095.00	1,360,616,193.35
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,964,272,495.70	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,967,157,603.43	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	997,114,892.27	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,440,000.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	3,440,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,224,500,000.00	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-2,224,500,000.00	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,224,500,000.00	-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	2,224,500,000.00	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	104,604,177,000.00	87,232,167,021.88	17,372,009,978.12	83.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,604,177,000.00	87,232,167,021.88	12,372,009,978.12	87.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,000,000.00	132,481,906.00	65,518,094.00	66.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,000,000.00	132,481,906.00	65,518,094.00	66.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000,000.00	132,481,906.00	65,518,094.00	66.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,406,177,000.00	87,099,685,115.88	12,306,491,884.12	87.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,406,177,000.00	87,099,685,115.88	12,306,491,884.12	87.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	99,406,177,000.00	87,099,685,115.88	12,306,491,884.12	87.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000,000.00	0	5,000,000,000.00	-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	5,000,000,000.00	0	5,000,000,000.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	104,604,177,000.00	173,713,671,750.62	(69,109,494,750.62)	166.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	94,604,177,000.00	145,419,236,430.97	(50,815,059,430.97)	153.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,332,811,400.00	42,294,236,655.83	(5,961,425,255.83)	116.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000,000.00	10,458,705,246.29	(9,158,705,246.29)	804.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	51,971,365,600.00	92,666,294,528.85	(40,694,928,928.85)	178.3
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,000,000,000.00	0	5,000,000,000.00	-
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	10,000,000,000.00	28,294,435,319.65	(18,294,435,319.65)	282.9
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	10,000,000,000.00	28,294,435,319.65	(18,294,435,319.65)	282.9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн
2	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН (II)		8,387,851,513.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,387,851,513.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,818,258,696.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		189,786,059.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		87,100,486.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		102,685,573.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,628,472,637.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		985,378,437.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		643,094,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,569,592,817.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		4,150,339,021.07
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		4,150,339,021.07
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,233,800,399.93
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,233,800,399.93
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		1,185,453,396.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		848,107,828.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		337,345,568.00
I	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		8,387,851,513.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		8,387,851,513.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		2,575,932,713.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан		39,890,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,759,838,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		12,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		190,350.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад он дамжсан авлагын барагдуулалт, шийдвэрлэлт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа болон удирдах дээд байгууллагын тогтоолыг хэрэгжүүлэх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/344 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг зорилтот бүлгийн хүн амд оновчтой хүргэх, чанар, хүртээмж, үр ашгийг сайжруулах замаар иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Иргэний хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын жишигт нийцүүлэн мэргэжлийн боловсрол, ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны соёл төлөвшүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлж, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бодлогын загварчлал боловсруулах, салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, хөгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай;”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн Хяналт, мониторингийн газар нь ХЭДС-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 79,509.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 795.1 сая төгрөгөөр тооцсон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,430.2 сая төгрөгөөр буюу 16.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилгаа, урт хугацаат өр төлбөр данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 192,839.1 сая, эцсийн үлдэгдэл 161,368.1 сая төгрөг болж 31,471.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
АВЛАГА	192,839,158.2	161,368,145.6	(31,471,012.6)
Ажиллагсадтай холбогдсон авлага	48.0	48.0	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	100,924,350.3	87,346,394.2	(13,577,956.1)
Зээлийн хүүгийн авлага	79,324.2	207,471.3	128,147.1
Бусад авлага	4,228,970.2	4,155,706.2	(73,264.0)

Байгууллагаас авах авлага	3,028,100.7	3,019,990.8	(8,109.9)
Хувь хүмүүсээс авах авлага	1,200,869.5	1,135,715.4	(65,154.1)
Зээлийн авлага	87,606,465.5	69,658,525.9	(17,947,939.6)
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	77,381,965.5	59,434,025.9	(17,947,939.6)
Хувь хүмүүст олгосон зээл	44,151,997.3	42,542,236.7	(1,609,760.6)
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	33,229,968.2	16,891,789.2	(16,338,179.0)
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	10,224,500.0	10,224,500.0	0.0
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	10,224,500.0	10,224,500.0	0.0

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны бууралтад дараах авлагын барагдуулалт нөлөөлсөн байна. Үүнд:

- Татаас санхүүжилтийн авлагыг 100,896.1 сая төгрөгөөр барагдуулсан;
- Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Хаан банк 9,000.0 сая, Төрийн банк 6,900.0 сая төгрөгийн үндсэн зээлийн төлбөр болон зээлийн хүүгийн авлага 333.9 сая төгрөгийг тус тус төлсөн;
- Оёдлын нэгдсэн холбоо ТББ-ийн зээлийн авлага 438.2 сая төгрөгөөр хасагдсан;
- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн авлагын 4,284.8 сая төгрөг төлөгдсөн.

Аудитын илрүүлэлт:

- Дорноговь аймгийн ХЭДС 44 иргэнээс авах 622.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж акт үйлдээгүй,
- Баянзүрх дүүргийн ХЭДС 2015-2017 онд үүссэн 587.7 сая төгрөгийн эргэн төлөлтийн хугацаа дууссан авлагыг барагдуулаагүй.
- Зээлийн 32.7 сая төгрөгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, /Баянхонгор аймгийн ХЭДС 28.2 сая, Говь-Алтай аймгийн ХЭДС 2.4 сая, Сүхбаатар аймгийн ХЭДС 2.1 сая/
- Дархан-Уул аймгийн ХЭДС 0.1 сая төгрөгийн ажилчдын чадавх бэхжүүлэх зардалд нэг хүний зардал илүү олгосон.

3.5.2 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 17.4 сая, эцсийн үлдэгдэл 54.7 сая төгрөг болж 37.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Урьдчилгаа дансны үлдэгдэл

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	17,355.0	54,653.1	37,298.1
Дүн	17,355.0	54,653.1	37,298.1

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн “Оролцоо” төслийн суралцагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд зарцуулах зардлын 23.5 сая, оролцогчдод гардуулах сертификатын 11.4 сая, Ховд аймгийн ХЭДС-ийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах 19.7 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрүүд бүртгэлтэй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материал дансны эхний үлдэгдэл 2.0 сая, эцсийн үлдэгдэл 5.4 сая төгрөг болж 3.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), ууралт (-)
Түлш, шатах тослох материал	730.0	3,330.0	2,600.0
Бусад хангамжийн материал	1,292.5	2,152.5	860.0
Дүн	2,022.5	5,482.5	3,460.0

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн өсөлтөд Ховд аймгийн ХЭДС-ийн түлш шатахууны нөөц нөлөөлсөн байна.

3.5.4 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны эхний үлдэгдэл 36,514.2 сая, эцсийн үлдэгдэл 30,747.9 сая төгрөг болж өмнөх оноос 5,766.4 сая төгрөг болж буурсан байна.

Хүснэгт 4. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,531,780.7	19,958,678.5	(573,102.2)
Ажилчидтай холбогдсон өглөг	5,443.8	1,027.9	(4,415.9)
Зээлийн хүүгийн өглөг	74,184.1	-	(74,184.1)
Бусад өглөг	114,294.2	20,555.7	(93,738.5)
Байгууллагад төлөх өглөг	111,458.2	17,719.7	(93,738.5)
Хувь хүмүүст төлөх өглөг	2,836.0	2,836.0	-
Урьдчилж орсон орлого	18,244,483.5	19,935,219.0	1,690,735.5
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	18,244,483.5	19,935,219.0	1,690,735.5
Хөтөлбөртэй холбоотой өглөг	2,093,375.1	1,875.9	(2,091,499.2)
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,982,447.0	10,789,195.0	(5,193,252.0)
Нийт дүн	36,514,227.7	30,747,873.5	(5,766,354.0)

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны бууралтад дамжуулан зээлдүүлэх гэрээний хүрээнд Дэлхийн банкны төслийн хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн 5,190.5 сая төгрөгийн санхүүжилтийг Дэлхийн банк буцаан татсан, төв сан 74.1 сая төгрөгийн зээлийн хүүгийн өглөг, хөтөлбөр, арга хэмжээтэй холбоотой 2,187.3 сая төгрөгийн өрийг барагдуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Налайх дүүргийн ХЭДС татварын цахим системд татварын өглөгийн үлдэгдэлгүй гэж тайлагнасан ч санхүүгийн тайланд 3,060.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 130,680.4 сая төгрөг болж, өмнөх оноос 25,663.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ , бууралт /-/
Хуримтлагдсан үр дүн	156,344,308.0	130,680,407.7	(25,663,900.4)
Өмнөх үеийн үр дүн	156,105,685.4	156,420,846.2	315,160.8
Тайлант үеийн үр дүн	238,622.6	(25,740,438.5)	(25,979,061.1)
Засгийн газрын хувь оролцоо	156,344,308.0	130,680,407.7	(25,663,900.4)

Эх сурвалж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 25,663.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 32,737.4 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналыг 3,136.0 сая төгрөгөөр бууруулж 29,601.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 104,604.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, нийт зарлагын эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны орлогоос 36,322.8 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 1,300.0 сая, урьд оны үлдэгдлээс 51,971.4 сая, гадаадын эх үүсвэрээс 5,000.0 сая, дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэж төлөгдөх төлбөрөөс 10,000.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 42,294.2 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 10,458.7 сая төгрөгийг бүрдүүлж, урьд оны үлдэгдлээс 92,666.2 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Дамжуулан зээлдүүлсэн зээлээс тайлант онд 28,294.4 сая төгрөг эргэн төлөгджээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 87,232.2 сая төгрөг буюу 83.4 хувьтай байгаа нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 12,495.9 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 65.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсан, гадаадын төслийн зээлээс санхүүжих 5,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Сүхбаатар аймгийн ХЭДС 11.4 сая төгрөгийн тушаал, шийдвэр гаргаагүй, томилолтоор ажилласан илтгэх хуудасгүй, томилолтын хуудсыг хаагаагүй, 10.7 сая төгрөгийн шатах тослох материалын зарцуулалтыг бүрэн тайлагнаагүй, Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тооцоо судалгааг бодитой гаргаагүй, хэрэгжих нь тодорхойгүй төслийг сонгон шалгаруулж 14.0 сая төгрөгийг олгосон;
- Архангай аймгийн ХЭДС тайлант онд төвлөрүүлэх орлого 172.0 сая төгрөгөөр тасарсан;
- Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний татварын цахим и-баримтыг бүрдүүлээгүй 19.7 сая төгрөг /Баянзүрх дүүргийн ХЭДС 13.4 сая, Чингэлтэй дүүргийн ХЭДС 5.2 сая, Багануур дүүргийн ХЭДС 1.1 сая/

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 2,575.9 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 39.9 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 5,759.8 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 12.0 сая нийт 8,387.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардалд 87.1 сая, аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардалд 102.6 сая, бараа үйлчилгээний бусад зардалд

1,628.5 сая, урсгал шилжүүлэг 6,569.6 сая төгрөг нийт 8,387.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,185.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл батлах тухай” 58 дугаар тогтоолоор баталсан төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон 2021 онд үйл ажиллагааны зардалд шаардагдах 11,808.6 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр тогтоосны дагуу “Оролцоо” төслийг хэрэгжүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 82.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 7 хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг баталсан байна.

Хүснэгт 6. Хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлт

	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин		2021 оны хүрсэн түвшин		Гүйцэтгэлийн хувь
		Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	
1	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	105,558.0	928,702.0	77,939.0	808,541.4	87.0
2	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	8,693.0	988,000.0	6,596.0	497,905.1	50.0
3	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	19,592.0	11,433,162.5	19,324.0	9,880,171.5	86.0
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	13,303.0	880,100.0	9,331.0	772,913.1	88.0
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3,174.0	8,377,308.5	3,440.0	6,432,839.5	77.0
6	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	900.0	1,404,000.0	941.0	1,216,672.0	87.0
7	Хүүхэд хамгаалагч төсөл	108.0	254,016.0	167.0	194,766.4	77.0
НИЙТ		151,328.0	24,265,289.0	117,732.0	19,803,809.0	82.0

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн гүйцэтгэл дунджаар 82.0 хувьтай байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт, түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 1.4 хувиар зөрүүтэй байна.

3.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан нь шилэн дансны цахим хуудсанд орлогын нийт тоон бус 149 мэдээлэл байршуулахаас 8 мэдээллийг хуулийн хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1. “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд...”, 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх,” гэсэн заалтуудтай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг тухайд нь, иж бүрэн байршуулж байх албан шаардлага өгөх.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан нь Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлогын 12.0 сая төгрөгийн 1, зардлын 639.6 төгрөгийн 38 ажил, гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1. “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд...”, 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх,” гэсэн заалтуудтай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг тухайд нь, иж бүрэн байршуулж байх албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. ХХААХҮЯ-ны 2013 онд Оёдлын холбоонд өгсөн зээлийг эргэн төлүүлэх шүүхийн шийдвэр гарсан бөгөөд 14,791.8 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 340 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмын 6.7-д “Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээнд заасан талуудын хүлээх үүргийн дагуу шүүхийн шийдвэр гарсан зээлийн эргэн төлөлт буюу авлагын хуваарийг гаргаж, барагдуулах арга хэмжээг холбогдох газартай хамтран хэрэгжүүлэх албан шаардлага өгөх.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан нь удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулахад 57.2 сая, танхимын цугларалт, салбарын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх ажлын томилолтын зардалд 6.2 сая, ширээний болон ханын хуанли хэвлүүлэх зардалд 11.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.5-д “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, төсвийн хэмнэлттэй ажиллах бодлого баримтлах албан шаардлага өгөх

3. “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн суралцагчид болон сургагч багш нарын сургалтын хэрэглэгдэхүүнийг нийлүүлэх” 119.9 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулах

үнэлгээний хорооны 2 удаагийн хурал нь 60.0 хувийн ирцтэй хуралдаж, гаргасан шийдвэрт хуулийн үндэслэлийг тусгаагүй, 2 гишүүний гарын үсэггүйгээр хурлын шийдвэр гарган, шууд худалдан авалт хийх зөвлөмж гаргаснаар Очир булнай ХХК-тай шууд гэрээ байгуулсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.8 “Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна”, 47.9 “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна”, Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 4.2. Үнэлгээний хорооны хуралдаан үнэлгээний хорооны дарга, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга болон бусад гишүүдийн дийлэнх олонх буюу 75 хувиас дээш ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдоно.” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, Сангийн сайдын 2014 оны “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын дагуу зохион байгуулах албан шаардлага өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, салбарын ажилчдын хурлыг танхимаар зохион байгуулж, дотоод томилолтын зардалд хөрөнгө зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 2,732.3 сая төгрөгийн 20 зөрчил илрүүлснээс 2,211.6 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, хариуцлага тооцох 1 албан шаардлага, 520.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 зөвлөмжийг өгсөн байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 20,350.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 3,378.5 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт.11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	7	239,400.0	6	124,184.5	1	115,215.5	51.9
Албан шаардлага	27	2,220,000.0	25	1,953,600.0	2	266,400.0	88.0
Зөвлөмж	52	24,930,600.0	46	22,063,581.0	6	2,867,019.0	88.5
Нийт дүн	86	27,390,000.0	77	24,141,365.5	9	3,248,634.5	88.1

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн харьяа байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар авч үзэх дараах асуудал байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл батлах тухай” 58 дугаар тогтоолоор баталсан төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон 2021 онд үйл ажиллагааны зардалд шаардагдах 11,808.6 сая

төгрөгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мөн оны батлагдсан төсвийн багцын хүрээнд зохицуулалт хийх замаар “Оролцоо” төслийг хэрэгжүүлэхэд санхүүжүүлсэн;

- ХХААХҮЯ-ны Оёдлын холбоонд дамжуулан зээлийн гэрээний дагуу олгосон хугацаандаа төлөгдөөгүй зээлд тооцсон 2,694,684.2 төгрөгийн алдангийг тус яам хүлээн зөвшөөрөөгүй маргаантай асуудлыг хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

- Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газраас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хяналт тавьж ажиллах;

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрт тусгасан болон тус сангаар дамжин хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн гүйцэтгэл, зарцуулалт, хүрсэн үр дүн, гадаадаас ажиллах хүч авах ажлын байрны төлбөрийн орлогын бүртгэл, тус орлогыг буцаан олгох зохицуулалт, сангаас олгож буй зээл олголт, зээлийн эргэн төлөлт, эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаандаа эргэн төлж буй эсэх, эдгээрт тавих хяналт зэргийг аудит хийх цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитад хамруулаагүй тул дараагийн аудитаар үргэлжлүүлэн үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,028.3 сая төгрөгийн 70 алдаа, зөрчил илэрснээс, 693.7 сая төгрөгийн 15 алдааг залруулж, 289.7 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 3,164.6 сая төгрөгийн 18 албан шаардлага хүргүүлж, 1,880.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 32 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт 5,334.6 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 795.1 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 34 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 31 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитаар “Зөрчилгүй” 23, “Хязгаарлалттай” 8 дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 6,028.3 сая төгрөгийн 70 алдаа, зөрчил илэрснээс, 693.7 сая төгрөгийн 15 алдааг залруулж, 289.7 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 3,164.6 сая төгрөгийн 18 албан шаардлага хүргүүлж, 1,880.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 32 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан

4.1.1 Албан шаардлага

Залуучуудын хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн зардал 17.2 сая, ажилд зуучлах болон ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний зардал 250.5 сая нийт 267.7 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа цахим и-баримтыг бүрдүүлээгүй. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.1 “албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ”, 17.5 “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын гүйлгээний төлбөрийн цахим баримтыг үндэслэн зарлагын гүйлгээг бүртгэх, татварын цахим системд худалдан авалтын бүртгэлд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага өгөх

4.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийн дэд сан:

4.2.1 Албан шаардлага

Санхүүгийн дэмжлэг олгох төслийн хүрээнд Ар амин хүсэл ХХК 7.0 сая, Таван бүрд ХХК 3.6 сая, Цэгц медиа ХХК 4.5 сая, Өв од баялаг ХХК-д 2.6 сая төгрөгийн олгосон зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмын 6.7-д “Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах албан шаардлага өгөх

4.2.2 Зөвлөмж

Илрүүлэлт

Байтаг зүр хайрхан ХХК-аас 0.7 сая, Цэнхэр тэс ХХК-аас 0.5 сая, Тулга тав Холбоо НҮТББ-аас 2.6 сая, Ээлтэй ертөнц ТББ-аас 1.9 сая, Энх аз амар ХХК-аас 1.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа цахим и-баримтыг бүрдүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс шаардан бүрдүүлж байх, татварын цахим системд худалдан авалтын бүртгэлд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс								Залруулсан		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт хамруулсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймгийн ХЭДС	АРА-2022/218/-СТА-ТШЗ	1	1					1	172,000.0									1	172,000.0
2	Баян-Өлгий аймгийн ХЭДС	БӨА-2022/186/НА-СТА-ТШЗ	1	1					0	-					0	-				
3	Баянхонгор аймгийн ХЭДС	БНА-2022/2/НА-СТА-ЗГТС	1	1					2	412,392.1			1	282,392.1					1	130,000.0
4	Булган аймгийн ХЭДС	БУА-2022/125/НА-СТА-ТШЗ	1	1					2	20,116.0		-		-		-		0	2	20,116.0
5	Говь-Алтай аймгийн ХЭДС	ГАА-2022/20/НА-СТА-ОНТС	1	1					3	17,814.6			1	2,412.0	2	15,402.6				
6	Дорноговь аймгийн ХЭДС	ДГА-2022/167/НА-СТА-ТШЗ	1	1					1	500,200.0					1	500,200.0				
7	Дорнод аймгийн ХЭДС	ДГО-2022/171/НА/СТА/-ТШЗ	1	1					1	164,200.0									1	164,200.0
8	Завхан аймгийн ХЭДС	ЗАА-2022/208/СТА-ТШЗ	1	1					1	568,311.4									1	568,311.4

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

9	Дундговь аймгийн ХЭДС	ДУА-2022/28/НА- СТА-ТШЗ	1	1				0	-									
10	Өмнөговь аймгийн ХЭДС	ӨМА- 2022/134/НА- СТА-ТШЗ	1	1				2	32,503.0	1	32,000.0			-			1	503.0
11	Өвөрхангай аймгийн ХЭДС	ӨВА- 2022/1/НА/СТА- ТШЗ	1	1				0	-									
12	Сүхбаатар аймгийн ХЭДС	СБА- 2022/176/НА- СТА-ТШЗ	1	1				5	42,627.5			1	2,052.5				4	40,575.0
13	Сэлэнгэ аймгийн ХЭДС	СЭА-2022/263- НА-СТА-ТШЗ	1	1				2	53,193.9								2	53,193.9
14	Төв аймгийн ХЭДС		1				1	0	-									
15	Увс аймгийн ХЭДС	УВА- 2022/184/НА- СТА-ТШЗ	1	1				2	513,420.4	1	511,920.4			1	1,500.0			
16	Ховд аймгийн ХЭДС	ХОА-2022/37/НА- СТА-ТШЗ	1		1			8	124,860.0	2	46,100.0	1	2,760.0	1	36,400.0		4	39,600.0
17	Хэнтий аймгийн ХЭДС	ХЭА- 2022/194/НА/ СТА-ТШЗ	1	1				0	-									
18	Хөвсгөл аймгийн ХЭДС	ХӨА- 2022/251/НА- СТА-ТШЗ	1	1				0	-									
19	Дархан- Уул аймгийн ХЭДС	ДАА- 2022/151/НА-СА- ТШЗ	1	1				1	120.0			1	120.0				0	-
20	Орхон аймгийн ХЭДС	ОРА-2022/2/НА- СТА-3ГТС	1	1				3	50,035.9	2	19,932.9	0		1	30,103.0	0	0	-
21	Говьсүм бэр аймгийн ХЭДС	ГСА-2022/1/СТА- 3ГТС	1	1				2	1,015.3	1	159.7			-			1	855.6

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

22	БНД-ийн ХЭДС	ХАК- 2022/765/НА-СА- ТШЗ	1	1				4	30,877.4	2	25,560.0							2	5,317.4	
23	БХД-ийн ХЭДС	ХАК- 2022/766/НА-СА- ТШЗ	1		1			1	16,373.5									1	16,373.5	
24	БГД-ийн ХЭДС	ХАК- 2022/763/НА-СА- ТШЗ	1		1			9	154,167.3	6	58,016.7			2	50,692.0			1	45,458.6	
25	БЗД-ийн ХЭДС	ХАК- 2022/770/НА-СА- ТШЗ	1	1				3	617,670.5					2	604,262.0			1	13,408.5	
26	НД-ийн ХЭДС	ХАК- 2022/767/НА-СА- ТШЗ	1		1			4	157,052.1					1	-			3	157,052.1	
27	СХД-ийн ХЭДС	ХАК- 2022/762/НА-СА- ТШЗ	1		1			3	1,224,473.3					1	892,248.5			2	332,224.8	
28	СБД-ийн ХЭДС	ХАК- 2022/764/НА-СА- ТШЗ	1		1			1	71,070.7					1	71,070.7					
29	ХУД-ийн ХЭДС	ХАК- 2022/768/НА-СА- ТШЗ	1		1			2	134,369.9					1	25,973.4			1	108,396.5	
30	ЧД-ийн ХЭДС	ХАК- 2022/769/НА-СА- ТШЗ	1		1			2	476,339.4					1	471,057.3			1	5,282.1	
31	Нийслэл ийн ХЭГ	ХАК- 2022/632/НА-СА- ТШЗ	1	1				1										1	-	
32	ХНХСИ	АХГ-2022/27/НА- СТА-ТШЗ	1	1				1	180,191.0					1	180,191.0					
33	ХБХХЕГ ХЭДС	АХГ-2022/15/НА- СТА-3ГТС	1				1	2	25,145.5					1	17,782.5			1	7,363.0	
34	ХХҮЕГ- ын ХЭДТС	АХГ-2022/15/НА- СТА-3ГТС	1				1	1	267,741.7					1	267,741.7					
	Дүн		34	23	8	-	-	3	70	6,028,282.0	15	693,689.7	5	289,736.6	18	3,164,625.0	-	-	32	1,880,231.4

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
1	Архангай ХЭДС	АРА-2022/218/-СТА-ТШЗ	1						1					
2	Баян-Өлгий ХЭДС	БӨА-2022/186/НА-СТА-ТШЗ	1	396,200.0					1	396,200.0				
3	Баянхонгор ХЭДС	БНА-2022/2/НА-СТА-ЗГТС	1	-					1	-				
4	Дорноговь ХЭДС	ДГА-2022/167/НА-СТА-ТШЗ	1	277,600.0					1	277,600.0				
5	Дорнод ХЭДС	ДГО-2022/171/НА/СТА/-ТШЗ	1	-									1	-
6	Өвөрхангай ХЭДС	ӨВА-2022/1/НА/СТА-ТШЗ	1	-									1	-
7	Өмнөговь ХЭДС	ӨМА-2022/134/НА-СТА-ТШЗ	2	-					1	-			1	
8	Дархан-Уул ХЭДС	ДАА-2022/151/НА-СА-ТШЗ	1	240,518.1									1	240,518.1
9	Орхон ХЭДС	ОРА-2022/2/НА-СТА-ЗГТС	1	125,250.8									1	125,250.8
10	Багануур ХЭДС	ХАК-2022/765/НА-СА-ТШЗ	1	-									1	-
11	Баянгол ХЭДС	ХАК-2022/763/НА-СА-ТШЗ	1										1	-
12	Налайх ХЭДС	ХАК-2022/767/НА-СА-ТШЗ	1	705,979.3					1	705,979.3				
13	Сонгинохайрхан ХЭДС	ХАК-2022/762/НА-СА-ТШЗ	1	-					1	-				
14	Сүхбаатар ХЭДС	ХАК-2022/764/НА-СА-ТШЗ	1	130,772.8									1	130,772.8
15	Хан-Уул ХЭДС	ХАК-2022/768/НА-СА-ТШЗ	1	8,171.5									1	8,171.5
16	Нийслэлийн ХЭГ	ХАК-2022/632/НА-СА-ТШЗ	1	16,000.0									1	16,000.0

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

17	ХНХСИ		1	180,191.0					1	180,191.0				
18	ХБХХЕГ ХЭДС	АХГ-2022/15/НА-СТА-3ГТС	1	651,600.0					1	651,600,0				
19	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар ХЭДТС	АХГ-2022/15/НА-СТА-3ГТС	1								1			
	<u>Дүн</u>		20	2,732,283.5	0	0	0	0	9	1,559,970.3	1	0	10	520,713.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 754/А0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/15/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийн зардал 17,252,200.00 төгрөг, ажилд зуучлах үйлчилгээний 87,679,500 төгрөг, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний 162,810,000.00 төгрөгийн зардал нийт 267,741,700.00 төгрөгийн ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтын иж бүрдлийг хангаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: ... 5.1.4. үнэн зөв байх...", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс шаардан бүрдүүлж байх, татварын цахим системд худалдан авалтын бүртгэлд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага өгөх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 462 /А 0160459

Улаанбаатар хот

АХГ-2002/15/НА-СТА-3ГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2013 онд Оёдлын холбоонд олгосон 14,791,789,216.57 төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх" журмын 6.7 "Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээнд заасан талуудын хүлээх үүргийн дагуу зээлийн эргэн төлөлт буюу авлагын хуваарийг гаргаж, барагдуулах арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны холбогдох газар, хэлтэст хариуцуулж, зохион байгуулах албан шаардлага өгөх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-414.Docx

0001081949



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 761/A0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/15/НА-СТА-377C
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийн суралцагчид болон сургагч багш нарын сургалтын хэрэглэгдэхүүнийг нийлүүлэх" 119,900,000.00 төгрөгийн бараа худалдан авалтын нээлттэй тендер шалгаруулах үнэлгээний хорооны 2 удаагийн хурал нь 60.0 хувийн ирцтэй хуралдаж гаргасан шийдвэрт хуулийн үндэслэлийг тусгаагүй, 2 гишүүний гарын үсэггүйгээр хурлын шийдвэр баталгаажуулан, Очир булнай ХХК-тай шууд худалдан авалтын гэрээ байгуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.8 "Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна, 47.9 Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна. Сангийн сайдын 2014 оны" Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам"-ын 4.2. Үнэлгээний хорооны хуралдаан үнэлгээний хорооны дарга, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга болон бусад гишүүдийн дийлэнх олонх буюу 75 хувиас дээш ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдоно." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах, Үнэлгээний хорооны гишүүдийн шийдвэрт дотоод хяналтыг хэрэгжүүлж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichin_Kheregi\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-417.Docx

9006109
9019120396

0001081955



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 25

№ 460/А0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/15/НА-СТА-377C

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан нь удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулахад 57,232,695.00 төгрөг, танхимын цугларалт, салбарын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх ажлын томилолтын зардалд 6,249,000.00 төгрөг, ширээний болон ханын хуанли хэвлүүлэх зардалд 11,600,000.00 төгрөг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх ... бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ гм)-ын зардлыг гаргахгүй байх", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

0001031953



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 456/А0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/15/НА-СТА-3ГТС
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд орлогын нийт 149 мэдээлэл байршуулахаас 8 мэдээллийг хуулийн хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 3.1 Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэсэн заалтуудтай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг тухайд нь, иж бүрэн байршуулж байх албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дарга Л.Дашдэмбэрэл, Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
901912039 10.10.20\Bichir_Khereg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Газар-4\3.Docx

0001081935



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 463/А.0160459
АХГ-2022/15/11А-СТА-3ГТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн дэмжлэг олгох төслийн хүрээнд Ар амин хүсэл ХХК 7,000,000.00 төгрөг, Таван бүрд ХХК 3,600,000.00 төгрөг, Цэгц медиа ХХК 4,550,000.00 төгрөг, Өв од барилга ХХК-д 2,632,500.00 төгрөг нийт 17,782,500.00 төгрөгийн олгосон зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 340 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмын 6.7 “Энэ журмын 6.4 6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн дарга Э.Тамир, ерөнхий нягтлан бодогч Ж.Хаш-Эрдэнэ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

0001081957



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 768/А0160459

Улаанбаатар хот

АХГ-2022/15/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан нь цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлогын 12,000,000.00 төгрөгийн 1 ширхэг, зардлын 639,600,000.00 төгрөгийн ажил, үйлчилгээний 38 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах хуулийн хугацааг хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд...”, 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэсэн заалтуудтай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг тухайд нь, иж бүрэн байршуулж байх албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн дарга Э.Тамир, ерөнхий нягтлан бодогч Ж.Хаш-Эрдэнэ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Б.НАРАНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

9006108 10.10.10.20\Bichig\Nereg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-426.Docx
9019120396

0001081979